



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 9 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.09.26

Дархан-Уул аймаг

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн хүрээнд:

Дархан-Уул аймгийн нутагт хэрэгжиж буй Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Барилга Хот Байгуулалтын болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаал шийдвэрийн дагуу ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2. дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2. дахь заалтын дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 28 дүгээр тогтоолоор тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэнд хяналт тавих, хангах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар:

Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйс бүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевизээр иргэн, хуулийн этгээд, олон нийтэд мэдээллийг өгч ажилласан.



Зураг 1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчилсан



Монгол Улсын иргэнд газар өмчлүүлийн чиглэлээр:

Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан.

Дархан сумын хэмжээнд 2022 онд 984 иргэнд 79.55 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн. Дархан сумд 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15, Малчин багийн нутаг дэвсгэрт 984 иргэнд 79.55 га газрыг 2023 онд өмчлүүлэхээр батлагдсан.

Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр лавлагааг авсан иргэдийн судалгаа:

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан **58** иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна.

- ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон

Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 12 албан бичгийн лавлагааг газрын кадастрын мэдээллийн сангаас шүүж хариуг хүргүүлсэн.

- ✓ Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд

оролцсон. /Батбармат ХХК, Ч.Чинбаатар, Айпүүлс ХХК, Мираклэнд ХХК/

- ✓ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаар нийт 61 иргэн, хуулийн этгээдийн ирсэн хүсэлтийг хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргын захирамжийн төсөл болон хариуг албан тоотоор хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын архивт нийт 30 ширхэг иргэн, хуулийн этгээдийн хувийн хэргийг хөтөлж, хүлээлгэн өгсөн.

Геодези, зураг зүйн, кадастрын хүрээнд:

Хаягийн зургийн дагуу 24 иргэн, 11 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.

Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 21 иргэн, 4 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн барилга байгууламж, зам, талбай, инженерийн шугам сүлжээний 10 улаан шугам, 7 гүйцэтгэлийн зургийг хүлээж авсан.

Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 913 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг гаргаж албан бичгээр хүргүүлсэн.



Иргэн Ө.Бадамын 2022 оны 06 сарын 13 нд Дархан-Уул аймгийн ГХБХБГ-т гаргасан өргөдөл гомдолыг хянаж үзээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа, байшин барьсан цахилгааны шугам татсан буруутай үйл ажиллагаа байх тул газрын гэрчилгээ олгуулах, өмч хөрөнгийг хохиролгүй болгуулах асуудлыг манай байгууллага шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдэж хариуг хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газраас “Очир-Ундраа” ХХК-ний гаргасан зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа газарт авагдсан солбицолыг кадастрын мэдээллийн санд оруулж шалгалган тухайн солбицол нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэр Бууртын орчим Зоолуур харын хөндийд байрлах тус компианы ашигт малтмалын эзэмшлийн талбайд байрлаж байгааг тодотгон хариуг хүргүүлсэн.

Дархан хотын гэр хороололын бүсээс мал туслах аж ахуйг гаргах, хотын ногоон байгууламжид мал оруулахгүй байх ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу малтай иргэдэд олгосон газарт очиж төлөвлөлтийн дагуу буусан эсэхэд шалгалт хийлээ. Нийт 12 айл төлөвлөлтөөр олгосон байршилд буусан байна.

Тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн хийсэн инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн материалыг нэгтгэн тайланг Able-ээр ГЗБГЗЗГ-ын ГУХ-ын мэргэжилтэн Г.Энхзаяад хүргүүлсэн.

Тагнуулын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалт” цахим сургалтанд хамрагдсан.

Кадастр чиглэлээр:

- ✚ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт/ хэмжилт хийлгэсэн 21 иргэний материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан.
- ✚ Улсын чанартай авто замын трассаас 2 тийш 50 м зайд орсон, мэдээллийн санд бүртгэлгүй 11 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.
- ✚ Шинэчилсэн бүртгэлд хамрагдах шаардлагатай 168 иргэний мэдээллийг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан.
- ✚ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дэргэдэх Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралд : Хамтран өмчлөгч хасуулах 4 иргэн, өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 13, Эзэмшил газрын талбай хэмжээ өөрчлөх 1, Шинээр өмчлөх хүсэлт өгсөн 13 иргэний материалыг бэлтгэж хуралд оруулсан.
Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралаас хасагдсан 5 иргэнд хариу мэдэгдлийг хүргүүлж ажилласан.
- ✚ Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 48 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.
- ✚ Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэгт орж Гэр хорооллын бүсээс мал, туслах аж ахуйг гаргах, зөвшөөрөлгүй буусан 9





5. Аймгийн Засаг даргын захирамжаар газрын эрх шилжсэн 18 иргэдийн гэрээг үүсгэж, иргэдэд утсаар мэдэгдэв.

6. 26 иргэний газар эзэмших эрх шилжүүлэх, зориулалт өөрчлөх, талбайн хэмжээ өөрчлөх хүсэлтийг хүлээн авч ГЭЗХХШийдвэрлэх хурлын материал бэлдсэн.

7. 2022.09.22-ны 09:00-17:00 цаг хүртэл “Монгол улсын газрын мониторингийн сүлжээг өргөжүүлэх, дундын мэдээллийн санг үүсгэх” салбар дундын уулзалт хэлэлцүүлэгт цахимаар оролцов.

Газрын төлбөрийн талаар:

- Аймгийн Татварын хэлтэст 2020, 2021 оны хүлээгдэж буй нэхэмжлэлийн жагсаалтыг 2022.09.06-ний өдрийн байдлаар гаргаж darkhan@mta.gov.mn хаягаар явуулсан.

Сумын нэр	2020	2021
Дархан	218,508,287	414,930,598
Орхон	2,544,726	5,230,178
Хонгор	36,714,284	95,430,726
Шарын гол	5,414,951	6,419,851
Нийт	263,184,268	522,013,374

- Төрийн албаны шалгалт ирэхтэй холбоотой ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, 4 төрийн албан хаагчийн хувийн хэрэгт үзлэг хийж, дутуу баримт бичгийг 2022.09.26-ний өдрийн дотор бүрдүүлэх жагсаалт гаргаж өгсөн.
- Миракл ланд ХХК-ий нэхэмжлэлтэй Аймгийн Засаг даргын 2022.06.07-ний өдрийн 01-А/164 дүгээр захирамжийг хүчингүй болгох Захиргааны хэрэгт 2022.09.05-ний өдөр ажиглагчаар оролцсон. Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Сонголон хайрхан ХХК-ий нэхэмжлэлтэй захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлэгт 2022.09.14-ний өдөр оролцсон бөгөөд тодорхойгүй хугацаагаар хурал хойшлогдсон. Мөн Жоконди ХХК-ий нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч бөгөөд хэргийн материалтай 2022.09.21-ний өдөр танилцсан. Хурал 2022.09.29-ний өдрийн 14:00 цаг хүртэл хойшлогдсон.
- ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 8 дугаар сарын 30 өдрийн А/159 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг байгуулах тушаалын гишүүнээр сонгогдсон бөгөөд 2022.08.30, 2022.08.23-ний өдрүүдэд цахимаар хуралд оролцсон. Тус ажлын хэсгийн зорилго нь Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотой газрын төлбөрийн ногдуулалт, төлөлт, тгазрын төлбөр тооцох аргачлал, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах цаашид шийдвэрлэх асуудлыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсэг юм. Дараах саналыг гарган хүргүүлсэн.

Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн талаар:

- Системд хүлээгдэж буй Нэхэмжлэлийн дүнг эцсийн дүнгээр харуулдаг болгох, ингэснээр 2020, 2021 оны газрын төлбөрийн өртэй иргэн, аж ахуй нэгж



байгууллагын үнийн дүн, тоо хэмжээг үнэн зөв, бодитой гаргахад тустай байна. Өнөөдрийн байдлаар системд үүсгэсэн нэхэмжлэл тус бүрээр орж харж эцсийн үлдэгдлийг харж байна. Тодруулбал, Нэхэмжлэлийн дүнгээс дутуу үнийн дүнгээр тушаасан байхад тэр нь бүтэн дүнгээр системээс татагдаж, харагдаж байна. Энэ нь төлбөрийн өр авлагын судалгааг үнэн зөв, бодитой гаргах боломжгүй байна.

2. Систем нэвтэрэхээс өмнөх онуудын /2015-2019 оны/ өр авлагыг ГХБХБГ нь Татварт том нэхэмжлэл үүсгэж өр авлагыг барагдуулж яваа. Татварт хэний хэн тушааж байгаа овог нэр, регистр, утасны дугаарыг бичдэг болгох хэрэгтэй байна. Өнөөдрийн байдлаар том нэхэмжлэлээр урд оны өр болон нөхөн бүрдүүлэлтээр орж ирж байгаа төлбөрүүдийг уг Том нэхэмжлэлээр тушааж байна. Үүнтэй зэрэгцээд хэний ямар төлбөр хаанаас орж ирж байгаа нь тодорхойгүй, тушаасан хүний овог нэр, регистр, утасны дугаарын мэдээлэл огт байхгүйгээр тушаагдаж явж байгаа. Мэдээж тодорхой, мэдэж байгаа орлогуудаа системдээ оруулж, хааж явж байгаа.

3. Төрийн Аудит, санхүүгийн байгууллагын хийсэн хяналт, шалгалт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх, сайжруулах, өгсөн зөвлөмжийн дагуу Газрын төлбөрийн хагас, бүтэн жилийн тайланд төлбөрийн үлдэгдлийн үнэн зөв, бодитой гарах нөхцлийг бүрдүүлж, төлбөр, татварын системийн хөгжүүлэлтийг яаралтай сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, Газрын нэгдмэл сангийн тайлангийн хугацаанд буюу дараа оны 01.15-ний өдрөөр тасалбар болгон газрын төлбөрийн тайланг системээс татахад дараа онд төлөгдсөн буюу 01 сарын 01-ний өдрөөс 15-ний өдрийг хүртэл төлөгдсөн дүн тайланд татагдаж улмаар Татварын төлбөрийн мэдээлэлтэй зөрөх, урд оны тайланд тусгагдахгүй дүн тайланд тусгагдаж орж ирсэн зөрчилтэй, мөн тухайн ондоо төлсөн төлбөрийн Төлөв өөрчлөгдөөгүйгээс тайлангийн үнэн зөв, бодитой байх нөхцөл бүрдэхгүй байна. Үүссэн нэхэмжлэлийн төлвийг заавал гараас шалгаж байх шаардлага тулгараад байна. Уг нь татварын систем 30 минут болоод мэдээлэл шинэчлэгддэг гэдэг зарчим үйлчлэхгүй байна.

4. Төлбөрийн тайлан гарахад урд оны дутуу төлөлт ямар эх үссвэрээс, яаж бодогдож орж ирсэн “Тайлбар хэсэг” програмд нэмэлтээр оруулах саналтай байна. Учир нь ямар нэг шүүхийн маргаан болоход нотлох баримт байхгүй, санхүүгийн хяналт шалгалтын үед хамгийн их шаардлагатай болдог. Тухайн үед бодолт хийгээд нөхөн төлбөр /өмнөх онуудыг нийлүүлээд/ гээд оруулдаг, төлүүлдэг дараа нь тайлбарлахад бэрхшээл үүсэж байна. Тухайн үед нь тайлбарыг сайн бичээд системд нэмэлтээр оруулаад өгвөл төлбөрийн түүх болон үлдэх сайн талтай.

Газрын суурь үнийн талаар:

Газрын суурь үнийн талаар боломжийн гэж харж байгаа. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар төлбөрийн “хувь хэмжээ”-г зөв тодорхойлж оруулбал болно. Хот тосгоны суурь үнийг 5 жил тутамд шинэчлэх саналыг хүргүүлж байна. Учир нь газрын төлбөр төлөгчдөд ойр ойрхон газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх нь санхүүгийн хүндрэл учруулдаг. 3 жилийн хугацаа гэдэг богино болохыг 2018 оны суурь үнэ өөрчлөгдсөнөөс харж болохоор байна. Өнөөдөр 2022 он газрын суурь үнэ хуулиараа өөрчлөгдсөн байх ёстой гэтэл үгүй. Энэ бүгдээс харахад шат дамжлаг ихтэй, Захиргааны ерөнхий хуулийн дагуу иргэдээс санал хүсэлт авах, мэдээлэл хүргэх, гэрээ шинэчлэх гээд процессын ажиллагаа их болсон.

Газрын зориулалтын талаар мөн эргэн харах учиртай:



Засгийн газрын тогтоолоор газар ашиглалтын 4 зориулалт зааж өгсөн. Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилалаар кодлогдон, газрын ашиглалтын зориулалт тус бүрээр газрын төлбөр бодогдож байгаа. Гэтэл газар ашиглалтын 4 зориулалтад тохируулж төлбөрийн хувь хэмжээг боддог. Хууль зүйн яаманд газрын төлбөрийн хувь хэмжээг хянуулж батлуулах үед гарсан хүндрэл байгаа. Зөвхөн 4 зориулалт дээр л төлбөрийн хувь хэмжээг тавих ёстой бусдаар газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилалаар газрын төлбөрийг бодно гэсэн хуулийн үндэслэл байхгүй гэж ихэнх аймгийг буцаасан хүндрэлтэй асуудал гарсан. Газар маш олон зориулалтаар ашиглагддаг. Тиймээс ялгавартайгаар хувь хэмжээг тогтоох, газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал гэдгийг баталгаажуулж хуулинд нэмэлтээр оруулж өгөх саналтай байна.

Газрын гэрээний зүйл заалтыг эргэн нэг хянах шалгах:

Газрын маргаанаар шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн ихэнх асуудал нь газраа зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй, газрын төлбөрөө цаг тухайд нь төлөөгүй гэсэн үндэслэлээр маргаан хийж байна. Газрын төлбөрийг Засаг даргын захирамж гарсан өдрөөр үү, гэрээ хийсэн өдрөөр үү, улсын бүртгэлд бүртгэгдэж Э дугаар авсан өдрөөр үү гэх мэт эргэлзээтэй асуудал гарч байна. Мөн 2 жил дараалан ашиглаагүй дээр гэрээ дүгнэх ажил хийгдсэн эсэхийг асууж лавладаг. Тиймээс гэрээ дүгнэх гэдэг хэсгийг програмд сайтар нэмж оруулж, 2 жил болоод дүгнүүлээгүй бол програмд эрхийг нь хязгаарладаг эсвэл сануулдаг байдлаар хөгжүүлэлт хийх саналыг хүргүүлж байна.

21 аймгийн газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, заавар зөвлөгөө зөвлөмж өгөх

Систем сайжруулах болон өдөр тутам гарч байгаа алдаа, хүндрэл бэрхшээлийг жилдээ нэг удаа ажил хариуцан ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг цуглуулж мэдээлэл солилцох, шинээр томилогдон орж ирсэн мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байх саналыг хүргүүлж байна. Учир нь нэг, 2 аймаг сайн ажиллаж байхад бусад аймаг, сумын газрын төлбөр, татварын мэдээ буруу гарахад улсын мэдээлэл үнэн зөв бодитой гарахгүй нь зүйн хэрэг.

✚ Аймгийн Засаг даргын 2022.09.06-ний өдрийн Талбай өөрчлөх 01-А/239 захирамжаар гарсан 2, хугацаа сунгах А/240 захирамжаар гарсан-9, эрх шилжүүлэх 01-А/240 захирамжаар гарсан 18, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан 12 нийт 41 иргэний гаражийн газрын гэрээ, гэрчилгээг бичиж, цахимд бүртгэсэн байна.

✚ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.09.14-ний өдрийн хурлаар хугацаа сунгах -1, эрх шилжүүлэх-10, талбай өөрчлөх-1 нийт 12 иргэний гаражийн асуудлыг танилцуулж захирамжийн төсөлд илгээсэн.

Шарын гол сум:

Сумын ИТХ-д 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг батлуулахаар албан бичиг хүргүүлсэн. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг үүсгэсэн. Усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн ахуйн бүстэй давхцалтай судалгааг bayarmaabekhochir@gmail.com



хүргүүлсэн. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын боловсруулалтыг “Газрын кадастрын цахим систем”-д оруулж тайланг сумын Засаг даргад хүргүүллээ.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 9, бусдад шилжүүлэх 3 бүртгэгдсэн байна. Сумын ЗДЗахирамжаар эзэмшил газрын талбай өөрчлөх 1, газар эзэмшүүлэх 2 ААНБ, өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх, 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж ажилласан.

Орхон сум:

Нэг. Газрын харилцаа, газар зохион байгуулалтын чиглэлээр

2021 онд газар өмчилж авсан нийт 24 иргэний материалыг хүлээлгэн өгсөн. Сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг батлуулсан. 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний санал 2 иргэнээс ирсэнийг хүлээн авч газрын системд оруулсан. Мөн Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын боловсруулалтыг “Газрын кадастрын цахим систем”-д оруулж тайланг сумын Засаг даргын албан бичгээр хүргүүлсэн.

Хоёр. Газрын кадастр, бүртгэл чиглэлээр

Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 19 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээ бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 28 бүртгэсэн байна. Тариалангийн талбайн хохирол тооцох ажлын хэсэгт орж тариалангийн талбай руу нь мал орсон 2 айлын газарт хэмжилт хийж зураглал гаргасан.

Гурав. Газрын төлбөр болон газар эзэмших дуудлага худалдааны чиглэлээр:

Тайлант хугацаанд нийт 9 иргэнтэй газрын төлбөрийн тооцоо нийлж газрын төлбөрийг төлүүлсэн. Газрын төлбөр нийт 15.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Газрын цахим бирж www.mle.mn сайтад 24 ширхэг үнийн мэдээ бүргэсэн.

Дөрөв. Бусад ажлууд

Зөвшөөрөлгүй дур мэдэн өвөлжөө барьсан 3 иргэнд газар чөлөөлөх 7 хоногийн хугацаатай албан мэдэгдэл өгсөн.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:

Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж



үзэн 4 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Үүнд:

- Орхон сум, 1-р багийн нутаг дэвсгэрт баригдсан 9-р цэцэрлэгийн өргөтгөлийн 15*17м хэмжээтэй барилга



- Дархан сум, 3-р баг, “Херо хүдэр” ХХК-ний төмрийн хүдэр нойтон баяжуулах үйлдвэр



Дархан сумын 1,4,7,12,16-р багуудад Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн 9206-МОН төслийн 5 ширхэг





Дархан сум, 31-р хорооллын гадна цэвэр ус, бохир, цахилгаан хашаажуулалтыг ажил



Барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:

Засгийн газрын 2021 оны 213 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилга байгууламжид олгосон. Үүнд:



- "Цайхун" ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны өргөтгөл 40.6*20.6м хэмжээтэй
- Дархан-Уул аймгийн Дархан сумын 1,7,8-р, Малчин багуудад хийгдэх Багц-4 гадна гэрэлтүүлэгийн ажил



- Дархан-Уул аймгийн Дархан сумын 2,3,5-р багуудад хийгдэх Багц-3 гадна гэрэлтүүлэгийн ажил

Шинээр баригдаж байгаа орон сууцны судалгаа гаргасан талаар:

Дархан-Уул аймагт баригдаж ашиглалтад орж байгаа орон сууцны барилгын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа / 2022.08.17 /





Дархан-Уул аймагт баригдаж байгаа шинэ орон сууцны үнэ ханшийн мэдээлэл / 2022.08.17-ны өдрийн байдлаар /										
№	Байгууллагын нэр	Орон сууцны нэр	Орон сууцны байршил	Айлын тоо	Ашиглалтад орох хугацаа	Өрөөний сонголт	Өрөөний хэмжээ /м.кв/	Барилгын гүйцэтгэлийн хувь хэмжээ	08-р сарын 17-ны өдрийн 1м2 үнэ	Холбоо барих утас
1	"Минж Проперти" ХХК	Парк Таун-2 хотхоны 9-р ээлж	Дархан сум, 14-р баг, 3-р хороолол	60	2023 оны I-р улирал	2-3 өрөө	55м2-79.5м2	9-р ээлжийн 1 блок барилга 50%-тай байна.	2.500.000 төг	99373477
2	"Мираклэнд" ХХК	Хүслийн хотхон 8-р ээлж	Дархан сум, 12-р баг, 14-р хороолол	216	2022 оны III-р улирал	2-4 өрөө	41м2-105м2	2 блок барилга 90%, 50%-тай байна	2.400.000 төг	80004488
3	Иргэн Б.Одгариг	Хийморь гарден	Дархан сум, 10-р баг, 24-р хороолол	178	2023 оны IV-р улирал	2-6 өрөө	65м2-214м2	4 блок барилга нийт 60%-тай байна	2.900.000 төг	99087112
4	"Баян Бридж" ХХК	315 Апартамент	Дархан сум, 11-р баг, 13-р хороолол	108	2022 оны III-р улирал	1-3 өрөө	35.5м2-73м2	1 блок барилга 95%-тай байна. Борлуулалт дууссан	2.700.000 төг	95911000
5	"Эм жи эл туннель системс" ХХК	Магнолиа хотхон	Дархан сум, 11-р баг, 13-р хороолол	45	2022 оны III-р улирал	2-4 өрөө	49.5м2-111м2	1 блок барилга 95%-тай байна.	2.300.000 төг	91673344 85044949
6	"Баян Бридж" ХХК	317 Апартамент	Дархан сум, 11-р баг, 13-р хороолол	108	2023 оны I-р улирал	1-3 өрөө	35.5м2-73м2	1 блок барилга 70%-тай байна.	2.500.000 төг	95911000
7	"Хэрлэн зураглал" ХХК	Даймонд апартамент	Дархан сум, 11-р баг, 13-р хороолол	108	2022 оны III-р улирал	1-3 өрөө	31.48м2-73.14м2	1 блок барилга 95%-тай байна. Борлуулалт дууссан	1.900.000 төг	88009246 88009247
8	"Хэрлэн зураглал" ХХК	Грийн таун	Дархан сум, 10-р баг, 11-р хороолол	180	2023 оны II-р улирал	1-3 өрөө	35.15м2-71.57м2	2 блок барилга 10%-тай байна.	2.500.000 төг	88009246 88009247
9	Иргэн Ц.Ганбаяр	Цэлмэг апартамент	Дархан сум, 14-р баг, 2-р хороолол	63	2023 оны I-р улирал	2-3 өрөө	48м2-85м2	1 блок барилга 30%-тай байна.	2.400.000 төг	89066766 89003032
10	Иргэн Д.Зоригтбаатар	-	Дархан сум, 10-р баг, 12-р хороолол	108	2023 оны III-р улирал	1-3 өрөө	35.5м2-73м2	1 блок барилга 5%-тай байна.	Борлуулалт хийгдэж эхлээгүй.	-
11	"Очир дархан" ХХК	-	Дархан сум, 14-р баг	32	-	2-5 өрөө	-	1 блок барилга 10%-тай байна.	Борлуулалт хийгдэж эхлээгүй.	-
12	"ЦЦТО" ХХК	Гэгээн апартамент	Дархан сум, 9-р баг	60	2022 оны IV-р улирал	2-3 өрөө	39м2-69м2	1 блок барилга 65%-тай байна.	2.600.000 төг	99017881 99095912
13	"Монбамбай" ХХК	Элит хотхон	Дархан сум, 10-р баг	45	2023 оны II-р улирал	1-3 өрөө	27м2-67м2	1 блок барилга 50%-тай байна.	2.200.000 төг	88397758
14	"Стронгер" ХХК	Парагон вилла	Дархан сум, 11-р баг	156	2023 оны I-р улирал	1-3 өрөө	36м2-78м2	1 блок барилга 25%-тай байна.	1.850.000 төг	80105979

Явуулсан бичиг:

- "Дархан дуулга" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан сумын 11-р багт байрлалтай 12-р байрыг ашиглалтад оруулсан тухай тодорхойлолтыг албан бичгээр өгсөн.
- Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулж байгаа шилдэг барилга байгууламжийг шалгаруулах ажлын хүрээнд Дархан-Уул аймагт хийгдсэн шинэлэг өнгө үзэмжтэй, дотор зохион байгуулалт сайтай барилгуудын мэдээллийг хүргүүлсэн. Үүнд:

Твин парк хотхоны 54 айлын орон сууц
Буудай центрийн үйлчилгээний барилга
Шинэ алхам 620 хүүхдийн сургуулийн барилга

Инженер, дэд бүтцийн хүрээнд:

- ✚ **Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд:**
 - Цахир түмэн алтай ХХК-ний Шарын гол сумын дулааны шугамын өргөтгөлийн ажил
 - Өгөөмөр баян булаг ХХК-ний цэвэр усны шинэчлэлтийн ажил
 - ДСЦТС ХК жимс дэд станцын шинэчлэлтийн ажил.
- ✚ **Хүргүүлсэн албан тоот**
 - Мөнх болор эрдэнэ ХХК архитектор төлөвлөлтийн даалгавар хүсэх тухай албан тоотод хариу хүргүүлсэн.
 - Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК 2022.08.18 өдрийн №196 тоот албан тоотын хариуг хүргүүлсэн.
 - Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК ирүүлсэн албан тоотын хариуг хүргүүлсэн.



- Дархан суманд 2023 онд хийгдэх Хөгжлийн хөтөч гүйцэтгэж буй авто замын зураг төсөлд шаардлагатай газар олголтын захирамжийн төслийг боловсруулж ХБТХОХ-т хүргүүлсэн.

Оролцсон хурал

- Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хуралд 7 хоног бүрийн 2 дах өдөр оролцсон.
- Дархан сумын 6,7-р баг 1-р сургуулийн урд талын авто зам хийгдэхтэй холбоотой газар чөлөөлөлтийн хуралд оролцож чөлөөлөх айл өрхүүдтэй уулзалт хийсэн.


Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:


- Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 4 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагаанд гишүүнээр оролцож ажилласан. Үүнд:
- Дархан сум, 3-р баг, “Херо хүдэр” ХХК-ний төмрийн хүдэр нойтон баяжуулах үйлдвэр
- Дархан сумын 1,4,7,12,16-р багуудад Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн 9206-МОН төслийн 5 ширхэг контейнер тохижуулж суурилуулалтын ажил
- Дархан сум, 31-р хорооллын гадна цэвэр ус, бохир, цахилгаан хашаажуулалтыг ажил

Барилгын материалын чиглэлийн хүрээнд:

2022.08.25 - Дархан хөөсөнцөрийн үйлдвэр /Говийн наран сүлд ХХК/ -ийн бичиг баримтыг үзэж шалгав. Үйлдэр нь ерөнхий технологич байхгүй тул холбогдох баримт бичигтэй ирж уулзахыг зөвлөж үйлдвэрлэлийг цаашид үргэлжлүүлэх бол шинжилгээний бичиг, зөвшөөрөл авахыг тайлбарласан.

2022.08.29-нд ШУТИС-ийн лабораторит ирсэн дээжинд шинжилгээ хийсэн. 2022.09.05-нд Suitability tool (Тохиромжтой байршил тодорхойлох) болон Urban Performance tool (Хотын үзүүлэлт) аргачлалын сургалт онлайнаар зохион байгуулагдсан. Сургалтанд Газрын тохиромжит байршил сонгох аргачлал





2022.09.08 нд Хонгор сум 1-р баг Шийрийн бригад орчимд ажиллаж байгаа шохой, дайрга үйлдвэрлэж буй ААНБ-уудын бүтээгдэхүүнийг үзэж шалгалаа. Үүнд:

- ✓ Түмэн зул энерги ХХК худалдан авсан /Ворлддэйнт ХХК-2020 онд 7 га газар/. Гэхдээ газраа нэр шилжүүлж аваагүй байна. 2022 онд бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй гэж, технологийн зааврыг батлуулахаар /БМҮХолбоо-нд хүргүүлсэн
- ✓ Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК- Ворлддэйнт ХХК-аас 3 га газар худалдан авсан ба газрын гэрчилгээ удахгүй гарна. Мөн БМҮХолбоонд хүсэлтээ өгсөн байгаа.








- ✓ Иннова ложистик ХХК-тусгай зөвшөөрөлтэй, Мөнхболор Эрдэнэ ХХК Силикат ХКАлбан тоот өгсөн
- ✓ Идэрхайрхан ХХК-2021.07.27-2026.07.27 МҮ-2.1-тусгай зөвшөөрөлтэй, харин дайрга 5-20мм 2019.07.22-2022.07.22-нд тохирлын гэрчилгээ хугацаа дууссан, сунгуулах тухай мэдээлсэн. Тулгат шийр ХХК-2021.07.27-2026.07.27 МҮ-1.3-тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаагаа явуулж байна.



- ✓ Сутайн үхэр чулуут ХХК-иуд нь 2022 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай мэдээлэл авсан. МҮ-1.3 Цемент, шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч материалын үйлдвэр (Шатаасан шохойн үйлдвэрлэл) чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж байна. ААНБ нь өөрсдөө түүхий эдээ олборлож, бутлан ангилж, шатаасан шохойг гарган ажиллаж байна. Цаашид үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлөө шинээр болон дууссан хугацааг сунгуулж аймгийн мэдээллийн санд бүртгүүлж ажиллах, шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүнийг нийлүүлэх шаардлагатай байгааг тайлбарлан 2022.08.30 №532 албан тоотыг хүргүүлж ажилласан.



- ✓ Очир бетон ган ХХК бетон зуурмагийн үйлдвэрийн ашиглалтанд оруулах комисст ажилласан. Суурьт зуурмагийн /силос/ байрлуулсан байдал,



экспертизээр батлагдсан ажлын зураг, БХТөвд магадлал хийгдсэн зураг төсөл, гүйцэтгэгч компанитай хийгдсэн гэрээ зураг баримтуудыг шалгасан.



3. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛ:

Шүүхийн мэдээлэл:

- ✚ Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт холбогдуулж газар эзэмших эрхийг шилжүүлэхгүй байгаа нь хууль бус гэсэн нэхэмжлэлтэй хэрэг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хурал 2022/09/07-ны өдөр нэхэмжлэгч талын гомдлыг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.
- ✚ “Алтантүрүү” ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хуралдааныг нэхэмжлэгч талаас Гэрч оролцуулах хүсэлт гаргасан. Нэмэлт тайлбар гаргуулах, мөн шүүгчийг татгалзсан тул шүүх хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.
- ✚ 2022/09/22-нд Бадрал Өргөө ХХК-аас 2022/08/18-наас 559 дугаартай захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд гомдол гаргасан. УДШүүхийн хурлын тов зарлагдаагүй байна.
- ✚ Нэхэмжлэгч Миракланд ХХК, болон Ч.Чинбаатарын аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 2022 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн захирамжаар Нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- ✚ Нэхэмжлэгч Батбармат болон Жоконди ХХК-аас Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01-А/163, 01-А/158 захирамжуудыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн
- ✚ Отгоны нэхэмжлэлтэй Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01-А/160 захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- ✚ Бадрал Өргөө ХХК-аас 2022/09/22-нд Бадрал Өргөө ХХК-аас 2022/08/18-наас 559 дугаартай захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд гомдол гаргасан. Шүүх хурал товлогдоогүй байна.
- ✚ Тахько ХК, Мотесн ХХК-ийн нэхэмжлэлтэй Чингэлтэй дүүргийн ИХАШШШүүгчийн 2021/01/21-ний өдрийн 182/ШШ2021/00188 захирамжаар



“..Дархан-Уул аймгийн ЗД-ын 2016/04/25-ны өдрийн А/107 тоот шийдвэрээр “Тахько” ХК-д олгосон 19.4 га газраас 15 га газрыг нэн даруй шилжүүлэх, үүнээс хойш 1 жилийн дараа 4.4 га газрыг тус тус Мотесн” ХХК-д олгуулах, шилжүүлэх захирамж гаргахгүй байгаа эс үйлдлийг хууль бус болохыг тогтоож, тухайн захирамжийг гаргахыг даалгах тухай нэхэмжлэлийн хариу тайлбарыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.


- ✚ Нэхэмжлэгч Ц.Гэрэлийн Дархан сумын Засаг даргын 2021/12/24-ний өдрийн А/85 захирамжийн И.Долгорт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, Ц.Гэрэлийн нэр дээр Дархан-Уул аймаг, Дархан сум, 15 баг, Мангирт 7 хэсэг, 4-71 тоотын гэр бүлийн хэрэгцээний газрыг өмчлүүлж, өмчлөх эрхийн гэрчилгээ олгохыг даалгах нэхэмжлэлийн хариу тайлбарыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.
- ✚ Нэхэмжлэгч Альфа констракшн ХХК ГХБХБГ-нь 2022/05/06-ны өдрийн №22/28, 2022/06/20-ны өдрийн №22/50 албан бичгүүдэд хариу өгөөгүй нь эрх бүхий албан тушаалтан өөрийн шийдвэр үйлдэл /эс үйлдэхүй/ гээр газар эзэмшигч компаний хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэх нэхэмжлэлтэй Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн Дугаар 114/ШШ2022/007 захирамжаар Нэхэмжлэгчийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Хариуцагчаас анхан шатны шүүхийн шийдвэрт Давж заалдах гомдол гаргаагүй болно.

ЭБАТ:



- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын эрх зүйн харилцааны хуралдааны 9 дүгээр сарын хуваарийн дагуу Ашиг сонирхлыг зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 7 албан хаагчаас авч <https://meduuleg.iaac.mn/AOS/Login> бүртгэлд оруулсан. Газрын эрх зүйн харилцааны хуралдааны хуваарийн дагуу хуралдаж нийт **97** иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Мэдээлэл технологийн чиглэлээр:

Facebook хуудсанд ирсэн 31 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-08-25, 2022-09-08, 2022-09-20-ны өдрүүдэд цахим төв дээр жижүүрлэж иргэдэд газрын цахим системд хэрхэн нэвтрэх, хүсэлт илгээх талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.



2022-08-29-ний өдөр АЗДТГ-т болсон e-darkhan цахим хуудас, аппликейшны сургалтанд хамрагдаж, байгууллагын хэрэглэгч үүсгүүлэн, өөрийн мэдээллийг засварлаж, 2 хүсэлт ирсэний хариуг өгөв.




Архивт байгаа Дархан сумын Өргөө, 4, 5, 7, 8-р багуудын гаражийн зориулалттай газрын нэгж талбарын хувийн хэргүүдийг цэгцэлж янзлахад туслав.




Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл цэсний Газрын харилцаа хэсэгт 2ш /2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зар, санал өгөх QR код, 2023 онд Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын тогтоол батлагдсан тухай мэдээ/, мэргэжилтнүүдийн танилцуулгын QR кодоор нэвтрэх холбоосыг оруулав.



Байгууллагын Facebook хуудас болон сумдын даамлуудын фэйсбүүк хуудсанд 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зар, санал өгөх QR код, 2023 онд Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын тогтоол батлагдсан тухай мэдээ, Хонгор суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдсан тухай мэдээ оруулав.



2023 онд Дархан-Уул аймгийн Дархан сумын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хуучин суурьшлын бүсэд эзэмшиж байгаа хашааны газрыг нийт 984 иргэнд 79,55 га газрыг өмчлүүлэхээр Дархан сумын ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 11 дүгээр х... See more



#Нээлттэй #хаалганы #өдөрлөг
2022.09.19-ний өдөр Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж ажиллалаа. Өдөрлөгөөр:
1. Иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу заавар зөв... See more




Дархан-Уул аймгийн #Дархан, #Хонгор, #Орхон, #Шарын гол сумдын #2023 #оны #Тухайн #жилийн #газар #зохион #байгуулалтын #төлөвлөгөөнд 2022-10-01-ний өдрийг хүртэл #санал авч байна.
1. Саналаа бичгээр болон өөри... See more





Захиргааны хэргийн шүүхэд өгөх Миракл лэнд ХХК, Жоконди ХХК, иргэн Ч.Чинбаатарын эзэмших эрхийг цуцалсан газрын ашиглалтгүй байгааг харуулсан зургийг кадастрын хэмжилт хийж, баталгаажуулсан зургийг авч эргэн тойрны байршлыг харуулсан тайлбарын хамт хийж өгөв. 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зарын постерын эхийг сум, аймаг тус бүр дээр хийж, хэвлэж өгөв. E-darkhan цахим хуудасны хэрэглэгчийн ковер фотоны эх, Мэргэжилтнүүдийн хаягийн эх дээр QR код нэмж дахин өөрчилж бэлтгэв. Мэргэжилтнүүдийн хаягийг хэвлэж наав. Мэргэжилтнүүдийн QR кодыг хэлтэс тус бүрээр нь байрлуулан постерын эх бэлтгэн хэвлэж, байгууллагын үүдэнд байрлуулав. Тайланг АЗДТГ руу илгээв.



Үндэсийн дата төв рүү цахим хуудасны дискний зай дүүрсэн тул нэмж болох эсэхийг асуусан хүсэлт илгээв. Smart city төсөлд зориулсан цахим шилжилтийн танилцуулгыг хийж, АЗДТГ-т очин танилцуулав. Илтгэлийн файлыг засварлан АЗДТГ-ын мэргэжилтэн Чинбилэг рүү илгээв. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг илгээв.



Серверийн өрөөний кондишны илүүдэл усыг 1 удаа асгаж цэвэрлэв. Хонгор сумын газрын даамлын компьютерийн гэмтсэн програмыг засварлаж өгөн, шинэ сканерыг таниулан тохиргоог хийж өгөв. Шарын гол сумын газрын даамлын компьютерийг сольж хатуу диск, дэлгэцийн картыг нэмж суурилуулан форматлаж, хэрэглээний програмуудыг суулган, тохиргоог хийж, хэвлэгч, сканерыг таниулав. Хонгор сумын газрын даамлын компьютерт SSD диск нэмж суурилуулсан тул хэрэглээний програмуудыг суулган, тохиргоог хийж, хэвлэгч, сканерыг таниулав. Мэргэжилтнүүдэд дундын мэдээллийн сангийн файлуудаа цэгцэлж, хуулж авахыг анхааруулав.





Нярав:

50 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 49 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 134 ширхэгийг хүлээж авч бүртгэв.


Шаардах хуудсаар 6 төрлийн 32 ширхэг бараа материал олгов. 8-р сарын бараа материал, нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

ГХБХБГ-т 2022 оны 09 сарын 01-ний өдрөөс 09 сарын 26-ны өдрийн хооронд Агле программд нийт 110 албан бичиг /хариутай 93/, 32 өргөдөл /хариутай 32/ ирсэнээс 26 албан бичиг, 7 өргөдөл шийдвэрлэн, 67 албан бичиг, 25 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



Мөн Egazar.gov.mn системээр 177 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ

